



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/296.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Ховд шинэ асар” ХХК-ний хийж гүйцэтгэсэн 62 айлын орон сууцны дээврийн засвар /Жаргалант сум, Магсаржав баг/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Дөлбадрал - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Д.Нямтулга - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Д.Цогтхүү - Стандарт хэмжилзүйн хэлтсийн байцаагч

Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн архивын тасгийн дарга

Т.Батхуяг - “Ховд шинэ асар” ХХК-ний захирал

Нарийн бичгийн дарга:

Д.Тогтохбаяр

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн

2. “Ховд шинэ асар” ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН